



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/520

Мөрөн

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.2, 30.1.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5, 65.1.1, Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мал хамгаалах сангийн аюулгүйн нөөцөд байгаа өвс, тэжээлийг Улаан-Уул, Цагаан-Уул, Шинэ-Идэр зэрэг сумдын өвсний фондод тараан байршуулж байгаатай холбогдон гарах 8381425 төгрөгний зардлыг Мал хамгаалах сангийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас зарцуулсугай.

2. Өвс, тэжээлийг татан авч бүсийн бусад сум, малчдад хүргэхдээ тээврийн хөлсийг нэмж 1 боодол өвсний үнийг 8330 төгрөгөөр тогтоосугай.

3. Тогтоосон үнээр нөөцийн өвсийг борлуулж Хүнс хөдөө аж ахуйн газартай тооцоо хийхийг Улаан-Уул, Цагаан-Уул, Шинэ-Идэр сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумдад ачигдах өвс, тэжээлийн тээврийн хөлс 8381425 /Найман сая гурван зуун наян нэгэн мянга дөрвөн зуун хорин таван/ төгрөгийг Мал хамгаалах сангийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас зарцуулахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч /Н.Аззаяа/-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Ган-Очир, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Г.Батцогт нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД